



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/336

Зуунмод

Цугларалт явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Дүйцүүлэх албаны журам”-ын 1.6, 3.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай” 220 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5, аймгийн иргэдийн Төлөөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 19-ний 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн сургалтыг Зуунмод сумын төвд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулсугай.
2. Цугларалтад оролцох бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалт, дадлагыг батлагдсан хөтөлбөрийн дагуу сахилга зохион байгуулалтыг өндөр төвшинд явуулахыг Цэргийн штаб (Дэд хурандаа Т.Төмөрчөдөр)-д даалгасугай.
4. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа алба хаагчдыг үүргийн дагуу орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажилд оролцуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
5. Цугларалтын хугацаанд бие бүрэлдэхүүнд мэргэжлийн хичээл сургууль орох офицер, ахлагч болон бусад шаардлагатай зүйлээр дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч (Бригадын генерал Т.Лодойдамба)-д даалгасугай.
6. Цугларалтад хамрагдах Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн ирж, очих тээвэрлэх авто техникийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
7. Цугларалтад шаардагдах зардал 9.900.000 (есөн сая есөн зуу) мянган төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д, шилэн дансанд байршуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

8. Одоо төлөх
Салч тугаа

Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар
сарын 02 -ны өдрийн А/336 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт



ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААХ
ИРГЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Хугацаа	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Хоолны зардал	60 хүн	14 хоног	1 өдрийн 3 хоол 10500	8,820,000
2	Томилолт	2	14 хоног	12000	280,000
3	Түлээ, модны зардал				500,000
4	Алба хаагчдын сургалтын материал /үзүүлэн таниулах материал/	5	Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх	60,000	300,000
	Бүгд				9,900,000

ТӨСӨВ ЗОХИОСОН:

ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА

ДЭД ХУРАНДАА Т.ТӨМӨРЧӨДӨР

ХЯНАСАН:

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч.ЦЭЦЭГСҮРЭН